



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/380

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн 2024 оны 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/362 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахаар захирамжлагдсан "Шагайн харвааны иж бүрэн хэрэгсэл" хийхэд дэмжлэг үзүүлэх 15,000,000 (арван таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.


2. Орон нутгийн төсвийн тодотгол хийсний дараа Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 15,000,000 (арван таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн санд шилжүүлэн зохицуулалт хийхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын
20... оны ... дугаар сарын ... -ны
өдрийн ... дугаар захирамжийн
хавсралт

ХАНТАЙШИРЫН МЭРГЭЧҮҮД ТӨСЛИЙГ ДЭМЖСЭН СУМД

№	Авах сумд	Аймгаас санхүүжүүлэх	Сумдаас санхүүжүүлэх
	Баян-уул	2.400.000	2.500.000
	Бигэр	2.400.000	2.500.000
	Дарви	2.400.000	2.500.000
	Дэлгэр	2.400.000	2.500.000
	Жаргалан	2.400.000	2.500.000
	Тонхил	2.400.000	2.500.000
	Төгрөг	2.400.000	2.500.000
	Халиун	2.400.000	2.500.000
	Хөхморьт	2.400.000	2.500.000
	Цогт	2.400.000	2.500.000
	Цээл	2.400.000	2.500.000
	Чандмань	2.400.000	2.500.000
	Шарга	2.400.000	2.500.000
Аймгаас санхүүжүүлэх шаардлагатай нийт			31.200.000

__оОо__